



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

Зарим зохицуулалтын үйлчилгээний хөлс
төлөхийг түр зогсоох тухай

Монгол улсын хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлыг сайжруулах, идэвхижүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 26.2.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ тогтоох, төвлөрүүлэх журам батлах тухай 158 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 1.3 /андеррайтерийн үйл ажиллагаа/, 1.4 /төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламж, өмчлөх эрх бүртгэх үйл ажиллагаа/, 1.7 /үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа/ дахь хэсэгт заасан үйл ажиллагаа эрхэлдэг зохицуулалттай этгээдээс зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөхийг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл зогсоосугай.

2. 2015 оны зохицуулалтын үйлчилгээний хөлсөө төлсөн хавсралтад дурьдсан компаниудиаc андеррайтерийн үйл ажиллагааны хөлс төлөхийг 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл зогсоосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан өөрийн дүрэм, журам, төлбөр тооцооны програмд зохих өөрчлөлтийг хийж энэ талаарх мэдээллийг 14 хоногт багтаан Хороонд ирүүлэхийг зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх үүрэг бүхий этгээдүүдэд үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын 1,2 дахь заалтад заасан хугацаанд зохицуулалттай этгээдүүд харилцагчдад үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагаагаа идэвхижүүлэх, санхүү, төлбөрийн чадварын байдлаа сайжруулах талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн, үр дүнг улирал бүр Хороонд тайлагнахыг Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦГТТХТ” ХХК-д тус тус үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000772

Санхүүгийн зохицуулах хорооны
2015 оны 4 дүгээр сарын 01-ний
өдрийн 159 дүгээр тогтоолын хавсралт

2015 ОНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС ТӨЛСӨН КОМПАНИУД

УХА0410 5043239

/төгрөгөөр/

№	Компанийн нэр	Үйлчилгээний төрөл	Төлсөн дүн
1.	“Азиа Пасифик секьюритис” ХХК	андеррайтер	2 000 000
2.	“Дэу Секьюритис Монгол” ХХК		2 800 000
3.	“Ти Ди Би капитал” ХХК		2 500 000
4.	“Тэнгэр капитал” ХХК		2 300 000
5.	“Эм Ай Си Си” ХХК		1 000 000
6.	“Гаүли” ХХК		2 000 000
7.	“Евразиа капитал холдинг” ХХК		2 300 000
8.	“Монет капитал” ХХК /Ард секьюритис/		2 300 000

---oOo---